БАТЛАВ

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Б.ЗОРИГТБАЯР

ОРХОН АЙМГИЙН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ, ШИНГЭЭЛТИЙГ ТООЦООЛОХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 12 дугаар сарын 19 Орхон аймаг

1.	Зөвлөх үйлчилгээний үндэслэл	- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын засгийн газрын 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн тогтоолоор батлагдсан "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт 3.0"-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах; - НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулганаар батлагдсан тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэх; - Монгол Улсын хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-ын Ногоон хөгжил стратегийн зорилтыг хэрэгжүүлэх; - Орхон аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.6-д заасан "Хүрээлэн буй орчинд ээлтэй 'Ногоон хот'-ыг бий болгох" зорилтын арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх; - Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах зорилтын арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
2.	Зөвлөх үйлчилгээний зорилго	Орхон аймгийн хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн тооцооллыг Уур амьсгалын өөрчлөлтийн Засгийн Газар хоорондын мэргэжилтний хороо (УАӨЗГХМХ/IPCC)-ны 2006 оны арга зүй болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бусад арга зүйн дагуу хийж гүйцэтгэх; Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг тодорхойлон, тооцооллыг хийж, зөвлөмж гаргах;
3.	Хамрах хүрээ	Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын хэмжээнд
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	Тус ажлыг 3-5 сарын хугацаанд хийж дуусгах шаардлагатай бөгөөд гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг урьдчилсан байдлаар бэлтгэж захиалагчид танилцуулна. Ажил гүйцэтгэх хугацааг ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу тооцно.
5.	Гүйцэтгэх ажлын хэмжээ	Орхон аймгийн хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг холбогдох Олон улсын болон Монгол улсын стандарт, аргачлалд нийцсэн байдлаар тооцоолох.
6.	Зөвлөх үйлчилгээний ажлын бүрдэл	**1. Өгөгдөл цуглуулалт ба судалгаа:** - Орхон аймгийн хүлэмжийн хийн тооллого хийх салбаруудыг тодорхойлох, - Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцоолох аргазүйг тодорхойлох, - Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцоолох аргачлалын дагуу шаардлагатай дата мэдээлэл, өгөгдөл цуглуулах. **2. Хүлэмжийн хийх тооцоолол:** - Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийг олон улсад баталгаажсан арга, аргачлалын дагуу тооцоолох,

		- Орхон аймгийн хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийн үр дүнг тайлагнах (боломжтой бол сүүлийн 5-н жилээр). **3. Хүлэмжийн хийн ялгарал шингээлтийн талаар хийгдэх бусад ажил** - Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийг тооцоолсон аргачлал, бууруулах боломжийн талаар мэдлэг ойлголт өгөх 2-оос доошгүй удаагийн сургалтыг аймгийн холбогдох албан тушаалтнуудад хийх, - Цаашид хүлэмжийн хийн ялгарлыг нарийвчлан тооцоолоход шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох, аргачлал, зөвлөмжөөр захиалагч талыг хангах, - Олон улсын болон Монгол улсын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахтай холбоотой хийж буй сайн туршлага, бусад судалгаа болон зөвлөмжийг тайланд тусгах, - Олон улсын түвшний хүлэмжийн хийн магадалгаа, нотолгоонд бэлтгэх үйл ажиллагаа, баримт бичиг боловсруулалт, карбон кредит болон карбон зах зээлд оролцох боломжийн талаар зөвлөмж, зөвлөгөө өгч хамтран ажиллах, - Зөвлөх үйлчилгээний үр дүн болох тайлан, зөвлөмжийг аймгийн удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, хүлээлгэн өгөх;
	Тавигдах чадвар	Гүйцэтгэгч нь (мэргэжилтэн эсвэл хуулийн этгээд) зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дараах чадвар хангасан байна (чадварыг нотлох бичиг баримтуудыг хавсаргана). Үүнд: - Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн тооллого, тайлан гаргаж байсан туршлагатай байх (улс болон аймгийн ижил төстэй ажлын тайлан болон бусад баримтыг үндэслэнэ), - Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийг салбар бүрээр (Эрчим хүч, Зам тээвэр, Аж үйлдвэр, Хөдөө аж ахуй, Хог хаягдал, Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт ой болон бусад), тооцоолох мэргэшсэн чадамж бүхий хүний нөөцтэй байх, - Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцдог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу тооцоолох чадамжтай байх (УАӨЗГХМХ (IPCC)-ны 2006 оны арга зүйгээр тооцоолол хийх), - "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ын хүрээнд Конвенцын хэрэгжилтийн талаарх Үндэсний хоёр жил тутмын тайлан гаргаж байсан туршлагатай бол давуу тал болно.
8.	Арга, аргачлал	Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцоолох арга, аргачлал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: - Олон улс болон Монгол улсад даган мөрдөж буй Хүлэмжийн хийн тооллогыг УАӨЗГХМХ (IPCC)-ны 2006 оны арга зүй зэрэг олон улсад даган мөрдөж буй арга зүй, аргачлал, стандартад нийцэх, - ISO 14064: Хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, баталгаажуулах олон улсын стандарт.
	Бусад	Бусад нэмэлт шаардлага болон мэдээллүүд шаардахгүй, Тухай ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл шаардахгүй.
9.	Ажлын хяналт, шалгалт	Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагч талаас хүлээн зөвшөөрч баталсан гэрээ болон техникийн даалгаврын дагуу хяналтыг тавина. Захиалагч нь шаардлагатай үед хэдийд ч гүйцэтгэгчийн ажлын явцтай танилцах, ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээ мэдээлэл гаргуулж авах эрхтэй.

10.	Тайлан боловсруулалт, материал хүлээлгэн өгөх	Гүйцэтгэгч нь тайлан, зөвлөмж, аргачлал болон бусад холбогдох мэдээллийг Орхон аймгийн Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгнө. Үүнд: - Ажлын цар хүрээнээс хамааран ажил гүйцэтгэх каленьдарчилсан төлөвлөгөөний дагуу явцын болон үр дүнгийн тайлан, - Орхон аймгийн хэмжээнд хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийг салбар бүрээр тооцоолсон үр дүн, - Орхон аймгийн хэмжээнд 2027-2030 онд нэн тэргүүнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломжтой салбар, арга хэмжээний хүлэмжийн хийн бууралтын тооцоолол, болон санал зөвлөмж, - Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахтай холбоотой цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал, зөвлөмж (Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, карбон зах зээлд оролцох боломж), - Тайлан болон бусад холбогдох бичиг баримтуудыг тус бүр 2 хувь хэвлэмэл байдлаар, мөн цахим хэлбэрээр захиалагчид хүргүүлнэ.

ХЯНАСАН:

БОНХОБТХ-ИЙН ДАРГА Ж.БАТ-ӨЛЗИЙ

ЗӨВШИЛЦСӨН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА С.ЖАРГАЛСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

БОНХОБТХ -ИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ,
БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН У.ЧИГЭСТЭЙ